



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/505

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 17, 19, 20 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эмчилгээ хийлгэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн Мөрөн сумын иргэн А.Анх-Оргил, Г.Пунцаг, Б.Энхзаяа, Ч.Энхсайхан нарт тус бүр 300,000 (Гурван зуун мянган) төгрөг, Мөрөн сумын иргэн Д.Нямдалай, Я.Дариймаад тус бүр 500,000 (Таван зуун мянган) төгрөг, эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэхэд шаардлагатай арга хэмжээний зардалд 1,800,000 төгрөг (Нэг сая найман зуун мянган) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ө.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6712011117